



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/257

Номгон

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн т
байдлын зэрэгт шилжсэн үед авч хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "б", 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2021 оны 91 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/236, А/256 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 37 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварын тархалт Улаанбаатар хотод өсөн нэмэгдэж тус аймагт халдвар зөөвөрлөгдөн орж ирж тархах эрсдэл өндөр байгаа тул иргэд, олон нийтийнхээ эрүүл мэндийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй. Үүнд:

2. Гэрийн тусгаарлалт, ажиглалтад тавих хяналтыг чангатгаж, Онцгой комиссын гишүүдийг аймгийн Онцгой комиссын даргын баталсан хуваарийн дагуу хяналт тавьж ажиллуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, (хурандаа Г.Нэмэхбаяр)-д;

3. Ойрын болон дам хавьтлуудын хяналтыг чангатгаж, аймгийн Онцгой комиссын гишүүдийн оролцоотойгоор нэгдсэн хяналт, шалгалтыг зохион байгуулан, тусгаарлалт, ажиглалтад байгаа иргэдийн хөдөлгөөнд цахимаар болон дэлгэцээр тавих хяналтыг дээшлүүлж, сахилга, хариуцлагыг сайжруулж ажиллахыг Тагнуулын хэлтсийн дарга, (дэд хурандаа Р.Мэндбаяр)-д;

4. Дээрх хугацаанд коронавируст халдварын тандалт судалгааг хийж, дам хавьтал бүхий иргэдээс шинжилгээ авч шинжлүүлэх, байгууллага, аж ахуй нэгж, иргэдийг үе шаттайгаар дархлаажуулалтад хамруулахыг Эрүүл мэндийн газрын дарга, (Н.Энхжаргал)-д;

5. Аймгийн хэмжээнд нэгдсэн ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлыг хуваарь, төлөвлөгөө гарган зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж)-т;


621010647

6.Дээрх хугацаанд аймаг руу орох, гарах зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, тус аймгаас Улаанбаатар хот руу эрүүл мэнд, буяны ажил, хүнс, шатахуун, эм эмнэлгийн хэрэгсэл татан авах ажлаар зорчих иргэдийг нийслэлийн Онцгой комиссын зөвшөөрлөөр, Улаанбаатар хот болон бусад аймгуудаас тус аймагт эрүүл мэнд, буяны ажил, хүнс, шатахуун, өвс тэжээл, эм эмнэлгийн хэрэгсэл татан авах ажлаар зорчих иргэдийг аймгийн Онцгой комиссын зөвшөөрлөөр, аймаг дотор (өөрийн аймгийн сум хооронд) зорчих иргэдийг сумын Онцгой комиссын зөвшөөрлөөр тус тус нэвтрүүлэх, шаардлагагүй тохиолдолд Улаанбаатар хот болон халдварын тархалтын “Шар”, “Улбар шар”, “Улаан” түвшин бүхий аймгуудаас иргэдийг татан авахгүй байхыг Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, (Цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-д;

7.Аймгийн Онцгой комиссын шуурхай штаб, сумдын Онцгой комиссын Шуурхай штаб болон хяналтын пост, эргүүл хяналтад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг Онцгой комиссын нарийн бичгийн дарга (дэд хурандаа Э.Батбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

8.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хөдөлгөөний хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбогдуулан 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл хугацаанд өглөө 08:00 цагаас оройны 20:00 цаг хүртэл гудамж, нийтийн эзэмшлийн зам, талбайд эргүүл, хяналтын үүрэг гүйцэтгэх байгууллага, аж ахуй нэгжүүдийн хуваарийг хавсралтаар баталсугай.

9.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН